



ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН
ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2016 оны 12 сарын 27 өдөр

Дугаар А/58

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Радио долгионы тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Радио давтамжийн хуваарилалтын нэгдсэн бүртгэл хөтлөх журам"-ыг нэгдүгээр, "Радио давтамжийн зурвасыг ашиглах, төлөвлөх, хуваарилах журам"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

Хоёр. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын даргын 38, 39 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Гурав. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Харилцаа холбоо, шуудангийн бодлого зохицуулалтын хэлтэс /Д.Батбаяр/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЧИНБАТ

0000003

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн
газрын даргын оны ... сарын ... өдрийн
... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**РАДИО ДАВТАМЖИЙН ХУВААРИЛАЛТЫН НЭГДСЭН
БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ЖУРАМ**

2016 он

АГУУЛГА

Нэг.	Нийтлэг үндэслэл	3
Хоёр.	Нэр томъёоны тодорхойлолт	3
Гурав.	Төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг	3
	Зохицуулах хорооны эрх, үүрэг	3
Дөрөв.	Хяналт, хариуцлага	4
Тав.	Бусад зүйл	4

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтэд тодорхойлогдсон радио давтамж, радио давтамжийн зурвасыг ашиглагч байгууллага болон иргэдийн радио давтамжийн ашиглалт, техник тоног төхөөрөмжийн үзүүлэлтийг бүртгэх, мэдээллийг хадгалах, хамгаалах, шинэчлэх, нууцлах, ашиглах, мэдээлэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид “төрийн захиргааны байгууллага” гэх) нь радио давтамжийн хуваарилалтын нэгдсэн бүртгэл хөтлөх журмыг боловсруулж, батална.
- 1.3. Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид “Зохицуулах хороо” гэх) нь Олон улсын цахилгаан холбооны байгууллагын стандарт шаардлагыг хангасан програм хангамжийг ашиглан үндэсний радио давтамжийн нэгдсэн бүртгэлийг хөтөлнө.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

- 2.1. Радио давтамжийн хуваарилалтын нэгдсэн бүртгэл (цаашид “нэгдсэн бүртгэл” гэх) гэж Радио долгионы тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлогдсон бүртгэл болон радио давтамж, радио давтамжийн зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээлэл, нэмэлт, өөрчлөлтийн мэдээллийг бүртгэх, хадгалах, мэдээллийн сан үүсгэхтэй холбогдсон үйл ажиллагааг хэлнэ.
- 2.2. Олон улсын радио давтамжийн мастер бүртгэл (цаашид мастер бүртгэл гэх) гэж Олон улсын цахилгаан холбооны байгууллага (цаашид “ОУЦХБ” гэх)-аас гишүүн орнуудын радио холбооны үйлчилгээнд ашиглаж буй радио давтамж, техник, технологийн талаарх мэдээллийг бүртгэж буй мэдээллийн баазыг хэлнэ.

Гурав. Төрийн захиргааны байгууллага, Зохицуулах хорооны эрх үүрэг

- 3.1. **Төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг**
 - 3.1.1. Энэхүү журамд техник, технологийн болон бодлогын шинэчлэлтэй холбоотойгоор тухай бүр нэмэлт, өөрчлөлт оруулах;
 - 3.1.2. Радио давтамжийн хуваарилалтын нэгдсэн бүртгэлийг сайжруулах зөвлөмж, бодлогын чиглэлээр хангах;
 - 3.1.3. Радио давтамжийн хуваарилалтын нэгдсэн бүртгэлтэй жил тутам танилцаж, хяналт тавьж ажиллах.

3.2. Зохицуулах хорооны эрх, үүрэг

- 3.2.1 Энэхүү журмын дагуу ОУЦХБ-ын стандарт шаардлагыг хангасан програм хангамжийг ашиглан радио давтамжийн хуваарилалтын нэгдсэн бүртгэлийг хөтлөх;
- 3.2.2 Монгол Улсад бүртгэлтэй радио давтамж, техник технологийн талаарх мэдээллийг “мастер бүртгэл”-д бүртгүүлэх;
- 3.2.3 Радио давтамжийн хуваарилалтын нэгдсэн бүртгэлийн үйл ажиллагаанд дэвшилтэт техник технологи ашиглах;
- 3.2.4 Радио давтамжийн нэгдсэн бүртгэлийн програм хангамжийн мэдээллийн аюулгүй байдал, бүрэн бүтэн, найдвартай ажиллагааг хангах;
- 3.2.5 Байгууллага, аж ахуй нэгж, иргэдэд радио давтамж ашиглалтын тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг олгосон талаарх Зохицуулах хорооны шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор нэгдсэн бүртгэлд бүртгэх;
- 3.2.6 Нэгдсэн бүртгэлийн мэдээллийн шинэчлэлт, өөрчлөлтийг тухай бүр, үнэн зөв шуурхай хийх зорилгоор радио давтамж ашиглах зөвшөөрлийн гэрээнд холбогдох заалтуудыг оруулж, мөрдүүлэн ажиллах;
- 3.2.7 Нэгдсэн бүртгэлийн тайлан мэдээг жил бүр бичгэн хэлбэрээр Төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;
- 3.2.8 Зохицуулах хороо нь нэгдсэн бүртгэлийн системд эрх бүхий субъектээр хөндлөнгийн үнэлгээ 2 жил тутам хийлгэх;
- 3.2.9 Хуулиар олгосон бусад эрх.

Дөрөв. Хяналт, хариуцлага

- 4.1 Энэхүү журмын хэрэгжилтэд Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавина.
- 4.2 Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль болон Захиргааны зөрчлийн тухай хуулинд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Тав. Бусад зүйл

Энэхүү журмыг техник, технологийн болон бодлогын шинэчлэлтэй холбоотойгоор тухай бүр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.